

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

**Санамж:** Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавар нийт 76 оноотой. Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

1. Адилтгах замаар зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)  
**А. Нарийн голын хөндийн бууц суурин - 800000 жилийн өмнө**      **Б. Цагаан агуй - ?**  
A. 8000 жилийн өмнө      B. 300000 жилийн өмнө      C. 40000 жилийн өмнө  
D. 12000 жилийн өмнө      E. 730000 жилийн өмнө
2. Дээд палеолитын үед холбогдох Ховд аймгийн Буянт сумын нутагт орших Чандмань Хар үзүүрийн хадны зургийг ямар аргаар зурсан бэ? (2 оноо)  
A. Амьтны загварт урлаг      B. Зосон      C. Сийлмэл      D. Хадны зураг      E. Хийсвэр
3. Монгол оронд оршин суугчид үйлдвэрлэх аж ахуйд аль үеэс шилжсэн бэ? (1 оноо)  
A. Энеолит      B. Палеолит      C. Мезолит      D. Неолит      E. Хүрлийн үе
4. Неолитын үеийн Баянзагийн суурингаас аж ахуйн зориулалттай самбар чулуу, нухуур чулуун багаж олджээ. Үүнд дүгнэлт өгнө үү. (2 оноо)  
A. Неолитын үеийн чулуун багаж зэвсгүүд том хэмжээтэй байжээ.  
B. Самбар, нухуур чулууг ашиглаж ан амьтан агнадаг байжээ.  
C. Үр тариа цайруулж хүнсэндээ хэрэглэдэг байжээ.  
D. Хүмүүсийн дунд эд хөрөнгө, эрх мэдлийн ялгарал байсан.  
E. Самбар нухуур чулуугаар эмэгтэйчүүд гоёлын зүйлс хийдэг байсан.
5. Хүрэл, түрүү төмрийн үед холбогддог, Монгол нутгаас 1200 орчим олдоод байгаа түүхэн дурсгал аль нь вэ? (1 оноо)  
A. Буган хөшөө      B. Хиргисүүр      C. Дөрвөлжин булш  
D. Хадны зураг      E. Түүвэр олдвор
6. Монголчуудын байгуулсан анхны төрт улс аль нь вэ? (1 оноо)  
A. Хүннү      B. Сяньби      C. Жужан      D. Хятан      E. Их Монгол улс
7. НТӨ IV зуунд хятадын Жао зэрэг ванлигууд нүүдэлчдийн хувцсыг өмсөж, нум сумт морьт цэрэг байгуулжээ. Үүний учир шалтгаан юу вэ? (2 оноо)  
A. Хятадын эдийн засаг хямарснаас  
B. Нүүдэлчидтэй амжилттай дайтахын тулд  
C. Тагнан турших дайн хийхийн тулд  
D. Жао ванлиг Хүннүгийн хараат болсноос  
E. Шинэ газар нутгийг байлдан эзлэх зорилгоор
8. Моюнчур хааны үед ямар улс цэцэглэн хөгжсөн бэ? (1 оноо)  
A. Түрэг      B. Уйгур      C. Хятан      D. Жужан      E. Сяньби
9. Эртний улсуудын мал сүргийн бүтэц өнөөгийн монголчуудтай адил бөгөөд хамгийн цөөн тоотой мал аль нь вэ? (1 оноо)  
A. Хонь      B. Адуу      C. Үхэр      D. Тэмээ      E. Ямаа



10. Гиюй (Лаошан) шаньюйд Хань улсын ордны тайган Жун Хан хүчин зүтгэж байхдаа “Хүннүгийн хүн ам Хань улсын нэг тойрогт хүрэхгүй. Хүчирхэг байгаагийн шалтгаан нь хоол унд, хувцас хунар өөр. Хань улсад түшиглэхгүй учир болой” гэсэн сурвалжийн мэдээ нь ямар утга санааг илэрхийлж байна вэ? (1 оноо)
- A. Хүннү нар Хань улстай хувцас хунар, хоол, идээ ижил байсан.  
 B. Хүннү улс Хань улсад түшиглэдэг байсан учир хүчирхэг байсан.  
 C. Хүннү нар Хань улсын хүн амаас цөөн байсан учир хүчирхэг биш байсан.  
 D. Хань улсын хүн ам Хүннүгээс олон байсан учир хүчирхэг байсан.  
 E. Хүннү улс нийгэм, соёлын хувьд бие даасан хүчирхэг улс байсан.
11. Хүннүд НТӨ III зуун гэхэд Энэтхэгээс ямар шашныг дэлгэрсэн хэмээн үздэг вэ? (1 оноо)
- A. Христийн шашин    B. Бөөгийн шашин    C. Манихейн шашин  
 D. Лалын шашин    E. Бурхны шашин
12. Монголын эртний улсуудын соёлоос Хүннү улсын үед аль нь холбогдох вэ? (1 оноо)
1. Ахын дуу    2. Эсгий ширдэг    3. 12 жилийн цаг тоолол    4. Их, бага бичиг    5. Хар балгас
- A. 2, 3    B. 1, 2    C. 3, 5    D. 2, 4    E. 1, 5
13. Татарууд 1003 оны үед Хятаны нөлөөнөөс гарч, бие даасан байдалтай болжээ. Уг оныг зуунд шилжүүлнэ үү. (1 оноо)
- A. XI зууны I хагас    B. X зууны I хагас    C. X зууны II хагас  
 D. XII зууны I хагас    E. XI зууны II хагас
14. “Хоёр наран ургаваас  
 Худгийн усан ширгэюү  
 Хоёр хаан сууваас  
 Хамаг улсаа барьюу” хэмээн ямар сурвалжид тэмдэглэгдсэн бэ? (2 оноо)
- A. Судрын чуулган    B. Монголын нууц товчоо    C. Лу.Алтан товч  
 D. Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх    E. Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл
15. Чингис хааны өмнөх үеийн Монголчуудад холбогдох ойлголтыг зөв тохируулна уу. (2 оноо)
1. Тайш, сэцэн, мэргэн    a. Нийгмийн зохион байгуулалт  
 2. Хүрээ    b. Нийгмийн давхраажилт  
 3. Талын малчин, ойн анчин    c. Аж ахуй
- A. 1b 2c 3a    B. 1a 2b 3c    C. 1b 2a 3c    D. 1c 2a 3b    E. 1a 2c 3b
16. Их Монгол улсын үйл хэргийг удирдан явуулах нийт ноёдыг даргалах үүргийг хэнд хариуцуулсан бэ? (1 оноо)
- A. Шихихутуг    B. Го ван Мухулай    C. Цагадай    D. Хубилай    E. Үсүн өвгөн
17. 1211 онд Чингис хаан Алтан улс руу довтлох болсон шалтгаан юу вэ? (1 оноо)
- A. Аян дайны үед баруун гар болох холбоотны үүргээ биелүүлээгүй учир  
 B. Эцэг өвгөдийн гэрээсийг биелүүлэх, аюулгүй байдлаа хангах учир  
 C. 450 худалдаачдыг хөнөөж, элчийг хороож доромжилсон учир  
 D. Төрийн эрхэнд гарсан Найманы Таян ханы хүү Хүчүлүгийг дарах учир  
 E. Алтан улс, Тангуд улстай Монголын эсрэг гэрээ байгуулсан учир



18. Чингис хааны Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг ялгана уу. (2 оноо)

1. Их Монгол улсыг байгуулсан.
2. Торгоны замын үүрэг өндөр түвшинд хүргэсэн.
3. Евразийг дамнасан газар нутагт нэгдсэн дэг журам тогтоосон.
4. Мянгатын системийг буй болгов.
5. Өрнө, дорнын хооронд худалдаа, соёлын харилцаа хөгжив.
6. Хархорум хот дэлхийн нийслэл болох үндэс тавигдав.

A. 2, 3, 6      B. 1, 2, 3,      C. 3, 4, 5      D. 1, 4, 6      E. 4, 5, 6

19. 1229 онд Өгэдэйг Хэрлэний Хөдөө аралд хаан ширээнд залжээ. Чингисийн хэдэн он бэ? (1 оноо)

A. Чингисийн 23 он      B. Чингисийн 67 он      C. Чингисийн 70 он  
D. Чингисийн 40 он      E. Чингисийн 68 он

20. Мин улсын их цэрэг Хархорум хотыг хэдэн онд эвдлэн сүйтгэж шатаасан бэ? (1 оноо)

A. 1374 он      B. 1368 он      C. 1388 он      D. 1380 он      E. 1387 он

21. Мин улсын зүгээс монголчуудын худалдаа хийх хүсэлтийг хааж боогдуулж байв. Монгол улстай худалдаа хийхдээ зөвхөн нас залуу агт морьд, үржлийн насны гүүгээр арилжаа хийх “адуун засгийн бодлого” явуулдаг байжээ. Үүний учир шалтгаан юу вэ? (2 оноо)

- A. Монголчуудын цэрэглэх чадварыг бууруулж, өөрсдийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд
- B. Монголчуудын адуун сүргийн бүтцийг сайжруулж, өөрсдийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд
- C. Монголчуудад туслах замаар адуу худалдан авч, хүчээ зузаатгахын тулд
- D. Монголчуудыг уулгалан довтолж, асуудлыг хүчээр шийдвэрлэх байдлыг зогсоохын тулд
- E. Нүүдэлчдийг нүүдэлчдээр нь цохиулах хятадын төрийн уламжлалт бодлогыг явуулахын тулд

22. XVII зууны үеийн бие даасан улсуудаас **Цорос, Галдан бошгот, чуулган** зэрэг ойлголтууд нь аль улсад холбогдох вэ? (1 оноо)

A. Халхын хаант улс      B. Өвөр Монгол      C. Зүүнгарын хаант улс  
D. Хошууд улс      E. Хотгойд улс

23. 1640 онд Халх, Ойрад, Халимаг, Хошуудын эрх баригч 28 ноён язгууртнууд ямар нэртэй газар “Их цааз”-ыг баталсан бэ? (2 оноо)

A. Ар элстэй      B. Долоон нуур      C. Хөх хот  
D. Тарвагатайн улаан бураа      E. Хүрэн бэлчир

24. 1586 онд Абтай сайн ханы байгуулсан хийдийг 2004 онд Дэлхийн соёлын өвд бүртгэжээ. Энэ ямар хийд вэ? (1 оноо)

A. Эрдэнэзуу хийд      B. Амарбаясгалант хийд      C. Манзуширын хийд  
D. Шанхын хийд      E. Хөгнө Тарнын хийд



25. XVII зуунаас монголчууд бүх нийтээр шарын шашинд орсон шалтгаанд аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)

- A. Монгол, Төвөд хоёр нэгдэх зорилготой байсан тул шарын шашинд орсон.  
 B. Төвөдүүд улс төр, эдийн засаг, цэргийн дэмжлэг авах гэж шашнаа дэлгэрүүлсэн.  
 C. Манжууд Монголчуудын дайнч байдлыг бууруулахын тулд шашныг дэмжсэн.  
 D. Монголын язгууртнууд шарын шашныг ашиглан нэр хүндээ өсгөхийг зорьсон.  
 E. Монголын ард түмэн байнгын дайн самуунаас залхаж, шинэ шашныг хүлээн авсан.

26. XVI-XVII зуунд Монголчуудын зохиосон бичиг үсгийг цаг хугацаагаар нь эхлэлээс төгсгөл рүү зөв эрэмбэлсэн хэсгийг сонгоно уу. (2 оноо)

1. Тод үсэг	2. Соёмбо үсэг	3. Али гали үсэг
-------------	----------------	------------------

- A. 1, 3, 2      B. 1, 2, 3      C. 2, 1, 3      D. 3, 1, 2      E. 3, 2, 1

27. Манж Чин улсын эрхшээлд орсон Монголын хаант улсуудыг зөв ялгасан хэсгийг сонгоно уу. (1 оноо)

Манж Чин улс	1	Буриад Монгол
	2	Өвөр Монгол
	3	Зүүнгар
	4	Халимаг Монгол
	5	Халх Монгол

- A. 2, 4, 5      B. 1, 2, 3      C. 1, 4, 5      D. 3, 4, 5      E. 2, 3, 5

28. Лигдэн хаан хатуу засаглалд шилжиж, улс орноо цэргийн хүчээр нэгтгэхийг зорьж байсан нь ямар бодлогод хамаарах вэ? (2 оноо)

- A. Дайчин төрөөр нэгтгэх бодлого      B. Тайван төрөөр нэгтгэх бодлого  
 C. Шинэ засгийн бодлого      D. Шинэ эргэлтийн бодлого      E. Адуун засгийн бодлого

29. Баруун зүг Ижил мөрний адгаар Ойрад монголчуудын байгуулсан улсыг хожим юу гэж нэрлэх болсон бэ? (1 оноо)

- A. Торгууд      B. Буриад  
 C. Хошууд      D. Халимаг      E. Дөрвөд

30. Сөнөдийн Тэнгис ван харьяатаа дагуулан Халхын Сэцэн хан Шолойг түшихээр хэдэн онд ирсэн бэ? (1 оноо)

- A. 1639      B. 1648      C. 1646      D. 1640      E. 1636

31. 1688 оны Халх, Ойрадын дайны гол хор уршиг аль вэ? (2 оноо)

- A. Халхын нутаг Галдан хааны мэдэлд орсон.  
 B. Халх Монголыг Манжид дагаар ороход хүргэсэн.  
 C. Монгол Төвөдийн харилцаа муудахад хүргэсэн.  
 D. Халх, Орос улсын дайн тулааныг зогсоосон.  
 E. Монгол цэргийн хүчин чадлыг бууруулсан.



32. XIX-XX зууны эхэн үеийн Халхын 4 аймгийг газар зүйн байршлаар нь баруунаас зүүн рүү зөв эрэмбэлнэ үү. (2 оноо)

1. Сайн ноён аймаг 2. Түшээт хан аймаг 3. Засагт хан аймаг 4. Сэцэн хан аймаг

A. 4, 1, 2, 3 B. 3, 2, 1, 4 C. 2, 3, 1, 4 D. 3, 1, 2, 4 E. 2, 4, 1, 3

33. Монголчууд “үндсийг таслах, шашныг устгах” хэмээн ямар бодлогыг үзэж байсан бэ? (1 оноо)

A. Тайван төрөөр нэгтгэх бодлого B. Шинэ эргэлтийн бодлого C. Шинэ сэргэлтийн бодлого  
D. Шинэчлэлийн бодлого E. Шинэ засгийн бодлого

34. Дараах үйл явдлыг утгаар нь зөв харгалзуулна уу. (1 оноо)

a	1907 он	1	Өвөр Монгол руу 5 замын их цэрэг илгээв.
b	1912 оны 8-р сар	2	Хайсан, Алмас-Очир нар Хүрээнд ирж Халхын ноёдтой зөвлөлдөв.
c	1913 он	3	Монгол цэргүүд ховдыг чөлөөлөв.

A. a2 b3 c1 B. a1 b2 c3 C. a3 b2 c1 D. a3 b1 c2 E. a2 b1 c3

35. 1911 оны Монгол улсын засгийн газрын цэргийн яамны сайд хэн бэ? (1 оноо)

A. Г.Чагдаржав B. М.Ханддорж C. Г.Цэрэнчимэд D. С.Гомбосүрэн E. Э.Намсрай

36. 1913 онд “Монгол улсын хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ”-г батлав. Дүрэмд зааснаар олборлосон цагаан алт, очир алмас, эрдэнийн чулууны орлогын хэдэн хувийг татварлах вэ? (1 оноо)

A. 5-10% B. 10-15% C. 20-50% D. 30-60% E. 20-30%

37. 1921 оны хувьсгалын түүхэн зүтгэлтнүүдийг зөв ялгасан хэсгийг сонгоно уу. (1 оноо)

1921 оны хувьсгалын удирдагчид	1	Гүн Хайсан
	2	С.Данзан
	3	С.Зориг
	4	Л.Лосол
	5	Т.Намнансүрэн
	6	Ж.Батмөнх

A. 1, 3 B. 2, 4 C. 5, 6 D. 2, 1 E. 3, 4

38. 1921 оны хувьсгалд холбогдох үйл явдлыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (2 оноо)

1. Нууц бүлгэмүүд байгуулагдав
2. Хиагтыг чөлөөлөв
3. Монгол ардын нам байгуулагдав

A. 1, 2, 3 B. 3, 2, 1 C. 2, 3, 1 D. 1, 3, 2 E. 2, 1, 3

39. 1921 оны намар Хасбаатар, Дамбадорж нарын удирдсан цэргүүд 42 хоног хаана бүслэгдэн байлдсан бэ? (1 оноо)

A. Нийслэл хүрээ B. Улиастай C. Хиагт D. Ховд E. Толбо нуур



40. Зөвлөлт-Хятадын 15 зүйлт гэрээ бичгийн 5-р зүйлд (1924.5.31) “Зөвлөлт Засгийн газар Гадаад Монгол нь Дундад Иргэн Улсын нэг хэсэг мөн болохыг хүлээн зөвшөөрөх бөгөөд уг нутаг дэвсгэр дэх Хятадын бүрэн эрхийг хүндэтгэнэ” хэмээх сурвалжийн мэдээнд дүгнэлт хийнэ үү. (2 оноо)
- A. Уг гэрээгээр Монгол улсын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх боломжийг хаасан.  
 B. Уг гэрээгээр Зөвлөлтийн засгийн газар Монгол улсыг өөрийн нэг хэсэг гэж үзсэн.  
 C. Уг гэрээгээр Зөвлөлтийн засгийн газар Хятадтай нийлж Монголын газар нутгийг хувааж өөрийн нөлөөг тогтоосон.  
 D. Уг гэрээгээр Зөвлөлтийн засгийн газар Монголын тусгаар тогтнолыг Хятадаар зөвшөөрүүлэх бодлого явуулсан.  
 E. Уг гэрээгээр Зөвлөлтийн засгийн газар Хятадтай харилцахын тулд Монголыг ашигладаг байсан.
41. Анхдугаар Үндсэн хуулиар улсын нийслэлийг хэрхэн өөрчилсөн бэ? (1 оноо)
- A. Их хүрээ  
 B. Нийслэл хүрээ  
 C. Улаанбаатар  
 D. Хархорум  
 E. Өргөө
42. Монгол улс Бүгд найрамдах засаглалд шилжиж, анхдугаар үндсэн хуулиа баталсны 100 жилийн ой хэдэн онд тохиох вэ? (1 оноо)
- A. 2041 он  
 B. 2031 он  
 C. 2040 он  
 D. 2024 он  
 E. 2060 он
43. 1940 он гэхэд мал сүргийн тоо 26,204 мянгад хүрч, 1932 оныхоос 39.1 хувиар өссөн нь ямар бодлогын үр дүн бэ? (2 оноо)
- A. Шинэ сэргэлтийн бодлого  
 B. Эдийн засгийн үндсэн бодлого  
 C. Шинэчлэлийн бодлого  
 D. Шинэ засгийн бодлого  
 E. Шинэ эргэлтийн бодлого
44. Тусгаар тогтнолоо Хятадаар зөвшөөрүүлэх нөхцөлийг хангасан бүх нийтийн санал хураалт хэзээ болсон бэ? (1 оноо)
- A. 1945.10.20  
 B. 1945.9.21  
 C. 1911.12.29  
 D. 1924.11.26  
 E. 1921.7.11
45. 1960-аад оноос Монголд улс төрийн ямар дэглэм тогтсон бэ? (1 оноо)
- A. Ардчилсан  
 B. Тоталитар  
 C. Авторитар  
 D. Бүгд найрамдах  
 E. Цэргийн
46. 1979 оны МАХН-ын Төв Хорооны тогтоолд “... Хир буртаг өчүүхэн ч хүргэхгүй нандигнан хайрлаж, тахин шүтэж байх зүйл маань нэгдүгээрт нийгмийн өмч, хоёрдугаарт социалист өмчийг цогцлоон бүрдүүлэгч эх үүсвэр болсон ариун цагаан хөдөлмөр мөн” хэмээх сурвалжийн мэдээ түүхэн ямар үйл явдлыг илэрхийлж байна вэ? (1 оноо)
- A. Намын эсрэг бүлэглэл  
 B. Соёлын довтолгоо  
 C. Нэгдэлжих хөдөлгөөн  
 D. Сэхээтний төөрөгдөл  
 E. Атрын аян
47. Хүйтэн дайны үеийн сэргэлдөгч талуудад орох улсууд аль нь вэ? (2 оноо)
- A. Социалист орнууд- Монгол, ЗХУ**  
**B. Капиталист орнууд- ?**
- A. Баруун Герман, Хятад  
 B. Баруун Герман, Вьетнам  
 C. Дани, Умард Солонгос  
 D. Франц, Өмнөд Солонгос  
 E. Бельги, Польш



48. Өгөгдлийг ашиглаж зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)  
**(Олноо өргөгдсөний 12 он+Ардын хувьсгалын 73 жилийн ой):2+4=?**  
 A. 1961 онд Монгол улс НҮБ-д элсэв. B. 1981 онд Монгол хүн сансарт нисэв.  
 C. 1939 оны Халх голын дайн болов. D. 1945 оны Чөлөөлөх дайн болов.  
 E. 1976 онд Атрын II аян өрнөв.
49. Монголын Ардчилсан холбооны 10 гишүүн улс төрийн өлсгөлөнг хэзээ зарласан бэ? (1 оноо)  
 A. 1990.3.12 B. 1990.3.23 C. 1990.3.7 D. 1992.1.13 E. 1990.3.2
50. 1990 оны ардчилсан хувьсгал гарах болсон учир шалтгааныг зөв харгалзуулна уу. (2 оноо)  
 1. Гадаад шалтгаан a. Шашин шүтэх, эс шүтэх эрхийг хааж байв.  
 b. ЗХУ-д өөрчлөн байгуулалт эхлэв.  
 c. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо ноёлж байв.  
 2. Дотоод шалтгаан d. Социалист систем задарсан.  
 A. 1b,d 2a,c B. 1a,c 2b,d  
 C. 1b,a 2c,d D. 1d,a 2c,b E. 1c,d 2a,b
51. Монгол улсын хоёр дахь ерөнхийлөгч хэн бэ? (1 оноо)  
 A. Ц.Элбэгдорж B. Н.Энхбаяр C. Н.Багабанди D. П.Очирбат E. Х.Баттулга
52. 1992 оны Үндсэн хуулиар гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага аль нь вэ? (1 оноо)  
 A. Засгийн газар B. Улсын Их Хурал C. Шүүх  
 D. Үндсэн хуулийн цэц E. Ерөнхийлөгч
53. Чингис хааны мэндэлсний 840 жилийн ой хэдэн онд тохиосон бэ? (1 оноо)  
 A. 1990 он B. 2006 он C. 2022 он D. 2009 он E. 2002 он
54. Өгөгдлийг зөв тохируулна уу. (2 оноо)
- |   |         |   |  |
|---|---------|---|--|
| a | 1998 он | 1 | Монгол улсын түүх 5 боть нийтийн хүртээл болов.      |
| b | 1990 он | 2 | Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг батлав. |
| c | 2003 он | 3 | Монголын нууц товчооны 750 жилийн ойг тэмдэглэв.     |
- A. a3 b1 c2 B. a1 b2 c3 C. a3 b2 c1 D. a2 b3 c1 E. a2 b1 c3
55. 2014 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлог үйл явдал аль нь вэ? (1 оноо)  
 A. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг батлав.  
 B. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав.  
 C. Япон улсын ерөнхий сайд Тошику Кайфу айлчлав.  
 D. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав.  
 E. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан айлчлав
56. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын аль чиглэлд хамаарах вэ? (1 оноо)  
 A. Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах  
 B. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах  
 C. Дотоод аюулгүй байдлыг хангах  
 D. Хүний аюулгүй байдлыг хангах  
 E. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах



**ХОЁРДУГААР ХЭСЭГ**

**Санамж:** Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо  
**Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

**2.1** Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын байгуулагдсан он цагийг зөв тохируулна уу. (6 оноо)

- |           |                           |
|-----------|---------------------------|
| a. Хүннү  | 1. X зууны I хагас        |
| b. Жужан  | 2. 745                    |
| c. Сяньби | 3. НТӨ III зууны II хагас |
| d. Уйгур  | 4. 555                    |
| e. Түрэг  | 5. 156                    |
| f. Хятан  | 6. IV зууны I хагас       |

**2.2** Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох ойлголтыг зөв харгалзуулна уу. (6 оноо)

- |                  |   |
|------------------|---|
| a. Ил хаант улс  | 1. Мавераннахр, Могулистан                            |
| b. Кебек хан     | 2. Орос тэргүүтэй славян ба кипчак тэргүүтэй түрэгүүд |
| c. Их Юань улс   | 3. Нийт хүн амыг 4 зэрэглэлд хуваав                   |
| d. Цагадай       | 4. Цагадайн улс                                       |
| e. Марко Поло    | 5. Иран, Ирак, Азербайжан, Гүрж, Турк                 |
| f. Алтан орд улс | 6. Их Юань улс  |

**2.3** Түүхэн үйл явдлыг хамаарах он цагтай нь зөв тохируулна уу. (6 оноо)

- |   |         |
|---|---------|
| a. Алтан хан төвөд лам Содномжамцад “Далай лам” цол соёрхов.                | 1. 1586 |
| b. Дөчин, Дөрвөн хоёр “Их цааз” батлав.                                     | 2. 1639 |
| c. Абтай хан Эрдэнэзуу хийдийг байгуулав.                                   | 3. 1577 |
| d. Занабазарыг Анхдугаар Богдоор өргөмжлөв.                                 | 4. 1640 |
| e. Монголын улс төрийн төв эх нутагтаа шилжив.                              | 5. 1368 |
| f. Буйр нуурын ойролцоо Монгол, Мингийн их цэргийн хооронд тулалдаан болов. | 6. 1388 |

**2.4** Монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн арга хэлбэрүүдийг тохирох ойлголттой нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- |                                   |                           |
|-----------------------------------|---------------------------|
| a. Тэмцлээ бичгээр илэрхийлэв     | 1. Дугуйлангийн хөдөлгөөн |
| b. Сөнөдийн Тэнгис ван ардын хамт | 2. Алба хаях              |
| c. Ордосын хошууд өрнөв           | 3. Ганц нэгээрээ тэмцэх   |
| d. 1755-1758 оны бослого          | 4. Бөөнөөрөө оргон нүүх   |
| e. Харуул, өртөө                  | 5. Заргын бичиг           |
| f. Шилийн сайн эрс                | 6. Зэвсэгт бослого        |

